Зөрчлийн шинжтэй 704 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 100 буюу 14.2 хувьд нь зөрчлийн хэрэг нээж, 180 буюу 25.5 хувьд торгуулийн арга хэмжээ авч, 110 буюу 15.6 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, 35 буюу 4.9 хувийг шүүгчийн шийтгэвреэр баривчлан шийдвэрлэсэн нь нийт зөрчлийн 681 буюу 96.7 хувийг шийдвэрлэсэн байна. Шалгасан гомдол мэдээллийн 670 буюу 98.3 хувийг 0-3 хоногт шийдвэрлэсэн байна.

Тоо бүртгэлийн чиглэлээр 3 дугаар улирлын байдлаар мэдээллийн санд шивэгдсэн өргөдөл гомдлын 970 маягт, гэмт хэргийн 266 маягт, зөрчлийн 704 маягт, эрүүлжүүлэгдсэн хүний 881 маягт, захиргааны хяналтад байгаа хүний 35 маягтыг хянан төвлөрсөн тоо бүртгэлд авч, санд алдаатай шивэгдсэн 23 маягтыг буцаалгаж хариуцсан алба хаагчаар засуулан хяналт тавин ажиллав.

Тасаг, албадын дарга нар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн сан бүрдүүлэх /код 701/ журам”-ын 701.6.3, “Зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх /код 702/ журам”-ын 702.6.3-д заасан үүргээ хэрэгжүүлж байгаа байдал, алба хаагчдын мэдээллийн сангийн ашиглалт, бүрдүүлэлт, сангийн зөрчлийн талаарх танилцуулгыг бэлтгэн 7 хоног бүрийн “Пүрэв” гаригт нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, Цагдаагийн газрын даргад илтгэх хуудсаар хүргүүлэн ажиллаж байна.

Судалгаа хяналтын сангийн чиглэлээр гэмт хэргийг илрүүлэхэд ашиглах зорилгоор хамтарсан багуудаас объект, субъектийн 44 төрлөөр нийт 206 субъектийг бүртгэж картыг маягтын дагуу бичиж санд баяжилт хийлээ.

“Судалгаа, хяналтын мэдээллийн сангийн баяжилт, ашиглалтын байдлыг сайжруулах” арга хэмжээний хүрээнд тус тасгийн алба хаагч нараас судалгаа хяналтын санд гэмт хэрэг үйлдэж болзошгүй, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, байнга архидан согтуурч, гэр бүлдээ түгшүүр төрүүлдэг зэрэг 151 этгээдүүдийн мэдээллийг оруулан ажилласан байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн гомдол мэдээлэл болон эрүүгийн хэргийн тулгалтыг долоо хоногт 2 удаа аймгийн Прокурорын газрын тоо бүртгэлийн ажилтантай хийж, илэрсэн зөрчлийг тухай бүр нь арилгуулах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Чойбалсан хотын ундны эх үүсвэрийг хамгаалах тусгай салаа: Дотоодын цэргийн тухай хууль, цэргийн албаны тухай хууль, дотоодын цэргийн алба ажиллагаа, Цагдаа, дотоодын цэргийн командлагч, Дотоодын цэргийн штабын дарга, цагдаагийн газрын даргын тушаал, шийдвэрүүдийг удирдлага болгон улсын онц чухал объектын харуул, хамгаалалтыг ердийн болон хүч нэмэгдүүлсэн байдлаар зохион байгуулж, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцоход дэмжлэг үзүүлэх болон хуулиар хүлээсэн бусад чиг үүргүүдийг биелүүлж ажиллалаа.

Чойбалсан хотын ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалах тусгай салааны алба хаагчид 3 дугаар улиралд батлагдсан томилгооны дагуу “Дорнод НАА” ОНӨААТҮГ-тай байгуулсан харуул хамгаалалтын ажлын гэрээнд заасны дагуу Чойбалсан хот дахь цэвэр ус хангамжийн анги, цэвэр ус дамжуулах шугам насос, станцуудыг хамгаалах шалган нэвтрүүлэх 1 дүгээр пост, хяналтын 2, 3 дугаар постонд 358 удаа 8592 хүн /цагийн харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэсэн байна.

Салааны харуулчин, ахлагч нар 03 дугаар улиралд шалган нэвтрүүлэх 1 дүгээр пост, хяналтын 2, 3 дугаар постонд албан үүрэг гүйцэтгэх хугацаандаа цэвэр усны анги хориотой болон ариун цэврийн бүсэд өдрийн болон өглөө оройн ээлжинд гарч үүрэг гүйцэтгэн 1489 хүний бичиг баримт, биед үзлэг шалгалт хийж, гаднаас хамгаалалттай объектод албан ажлаар нэвтэрсэн 383 хүн, 780 тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалт хийж нэвтрүүлж ажиллалаа.

Улсын онц чухал объектын шалган нэвтрүүлэх 1 дүгээр пост, хяналтын 2, 3 дугаар постонд харуул хамгаалалтын ажил үүрэг гүйцэтгэсэн харуулчин ахлагч нар 4436 хөдөлгөөн хяналтад авч ажиллан нийт 19 зөрчил илрүүлэн ажиллажээ. Үүнд:

1. Объектод тогтоосон дэглэм журам зөрчсөн зөрчил 6
2. Хориотой бүсийн дэглэм журам зөрчсөн зөрчил 13

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын удирдлагад хамгаалалтын үйл ажиллагааны мэдээлэл болон хамгаалуулагч байгууллагын ажилчдаас илрүүлсэн зөрчил, харуул хамгаалалтад ашиглагдаж байгаа инженер техник хэрэгслийн засвар үйлчилгээ, бусад шаардлагатай

зүйлийн талаар албан бичгээр долоо хоног бүрийн Даваа гаригт өгч биелэлтийг тооцон ажиллаж, зөрчлийн талаар 6 удаа албан мэдэгдэл, шаардлага өгч, заагдсан зөрчил дутагдлыг засуулах арга хэмжээ авч ажиллав.

Дотоодын цэргийн штабын даргын "Сургалт, бэлтгэлийг зохион байгуулах" 2018 оны А/25 дугаар тушаал, түүний хавсралтаар баталсан "Дотоодын цэргийн алба хаагчдад 2019 онд зохион байгуулах албаны сургалт, бэлтгэлийн хөтөлбөр, хуваарь"-ын дагуу Чойбалсан хотын ус хангамжийн эх үүсвэр хамгаалах тусгай салааны офицер, ахлагч нарт 03 дугаар улиралд график төлөвлөгөө, хуваарийн дагуу салааны алба хаагчдад эрх зүй, цэргийн дүрэм, дадлага норматив, биеийн тамирын сургалтад алба хаагчдыг бүрэн хамруулан үр дүнг тооцон ажиллалаа.

Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргын 2019 оны 5/150 дугаартай албан бичгээр ирүүлсэн албаны сургалтыг 4 удаа зохион байгуулах үүрэг, ажлын чиглэлийн дагуу нийт бие бүрэлдэхүүний дунд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаар сургалтыг зохион байгуулж, 2 офицер, 16 ахлагчийг хамрагдсан байна.

Цагдаагийн газрын даргын баталсан "Гэр бүлээ сонсоё" арга хэмжээний удирдамжийн хүрээнд 19 алба хаагчийн гэр бүлтэй уулзаж, ахуй амьдралтай танилцаж, 09 дүгээр сарын 14-ний өдөр алба хаагчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд "Гэр бүлийн харилцааны мөн чанар" сэдвээр сургалт зохион байгуулан санал хүсэлтийг авч ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 17 дугаар зарлигийн хавсралтаар баталсан "Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд"-ээр долоо хоногт 2 удаа салааны алба хаагчдад албаны сургалт, жагсаалын бэлтгэлийг зохион байгуулан 14 алба хаагчийг хамруулан ажиллалаа.

Чойбалсан хотын ус хангамжийн эх үүсвэр хамгаалах тусгай салааны алба хаагчдын дунд 2019 оны 03 дугаар улиралд жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгийг 7 удаа, албаны бэлэн байдлыг 5 удаа зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг засуулан ажиллаж, алба хаагчидтай хэсэгчилсэн байдлаар 8 удаа уулзаж үүрэг чиглэл өгөв.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр: Тайлангийн хугацаанд малын хулгайн 10 холбогдогчтой 36.6 сая төгрөгний хохиролтой 16, бусдын малыг завшиж үрэгдүүлсэн 3 холбогдогчтой 56.1 төгрөгний хохиролтой 3, нийт 90.8 сая төгрөгний хохирол учруулсан 19 гэмт хэргийг илрүүлэн ажиллалаа.

Энэ хугацаанд эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад С.Чинзориг, цагдаагийн ахлах дэслэгч Б.Бямбадорж нар сумдын хэсгийн төлөөлөгч нартай хамтран малын хулгайн гэмт хэрэг илрүүлэх, мэдээ мэдээлэл цуглуулах чиглэлээр 1800 км зам маршрутын шалгалтын ажлыг хийж байна. Мөн Хэнтий аймгийн харьяат Л.Мөнхнаран, Л.Мөнхсайхан нар нь Дорнод аймгийн харьяат Д.Бөхчулуун, Ц.Эрдэнэбат нартай бүлэглэн Хэнтий, Дорнод аймгийн нутаг дэвсгэрээс 20 удаагийн үйлдлээр бусдын үхэр хулгайлсан хэргийг илрүүлэн шалгаж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код-307/ журамд заасны дагуу гэмт хэрэг илрүүлэх, тэмцэх үндсэн чиг үүрэг гүйцэтгэдэггүй алба хаагчдаас нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг, сэжигтэй этгээдүүдийн талаар мэдээ мэдээлэл, илтгэх хуудас бичүүлэн авч эрүүгийн төлөөлөгч нараар шалгуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Тайлангийн хугацаанд мал хулгайлах гэмт хэргийн талаар алба хаагчдаас ирүүлсэн 12 илтгэх хуудсыг шалгаж шийдвэрлэсэн.

"Бод мал", "Ченж", "Гарал үүслийн хяналт", "Мал-2019" зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 3 дугаар улиралд зохион байгуулж, 30 хоногийн хугацаанд 2 пост /хөдөлгөөнт эргүүл/ гарган ажиллуулж, хяналт шалгалтыг зохион байгуулав.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль бусаар мал, мах борлуулж байгаа үйлдлийг таслан зогсоох зорилгоор мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэл хариуцсан алба хаагчид болон олон нийтийн цагдаагийн хүчээр өдөр бүр хяналт шалгалтыг тогтмол явуулан ажиллалаа.

Мал мах худалдан борлуулах төвлөрсөн цэг, бөөний цэгүүдийн үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж ажиллах 3 олон нийтийн цагдааг ажиллуулж, тус цэг, захуудад худалдан борлогдсон мал бүрийг бүртгэж, зурагжуулах ажлыг зохион байгуулж, олон нийтийн цагдаа нарын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллав.

Аймгийн төв /Хэрлэн сум/-ийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг, бөөний цэгүүдийн үйл ажиллагааг шалгаж хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах, байгууллага, аж ахуйн нэгж дээрээ мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх /камерын хяналтыг сайжруулах, бүртгэл

хөтлөх, олон нийтийн цагдаа нарын хяналт шалгалтад тогтмол хамрагдах г.м/ чиглэлээр 11 аж ахуйн нэгжид 8 дугаар сард албан мэдэгдэл хүргүүлэн биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

“Ченж” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт мал, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, бэлтгэн нийлүүлэлт, экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэд /ченж/, аж ахуй нэгж, гадаадын иргэдийн судалгааг гаргаж, цагдаагийн хяналтанд авч ажиллан аймгийн төв Хэрлэн суманд мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг “Их чулуут” ХХК байнгын үйл ажиллагаа явуулж байгаа бол “Дорнод Мах маркет” ХХК нь улирлын чанартайгаар мал, мах бэлтгэх үйлдвэр ажиллуулж, “Шүр”, “Онон” захуудад иргэдийн өдөр тутмын хэрэгцээний махыг борлуулж байгаад хяналт тавин ажиллав.

“Хөвчийн тал”, “Дорнын алтан тал”, “Талын таван толгой”, “Дорнод Хаан хүнс” ХХК зэрэг компаниуд бөөний үнээр их хэмжээгээр мал, мах бэлтгэж байгаа ба Улаанбаатар болон бусад газрын байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ хийж аймгийн төвд мал, мах бөөнөөр нь авч байгаа 2 цэг байгаа бол өөрсдөө мал мах бөөний үнээр авч Улаанбаатар хотруу зарж борлуулдаг 6 цэг үйл ажиллагаа явуулж байна.

Хэрлэн суманд мал, мах худалдан борлуулж байгаа 150 орчим ченж, бусад сумдад 50 гаруй ченж үйл ажиллагаа тогтмол явуулж байгаа ба тэдгээрт хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах чиглэлээр санамж, мэдэгдэл өгч, худалдагдаж байгаа мал, маханд заавал гарал үүслийн гэрчилгээтэй байх, мал нэг бүрийн зургийг авч, бүртгэл хөтлөх шаардлагыг тавьж, хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллалаа.

“Гарал үүсэл хяналт” арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд мал, мах ихээр авдаг 11 ченж, мал, мах байнга авдаг 12 аж ахуй нэгжийн судалгааг гаргаж, өдөр бүр олон нийтийн цагдаа нараар тогтмол хяналт шалгалтыг хийлгүүлж ажиллалаа. Мөн мал, мах худалдан авдаг иргэд /ченж/, аж ахуй нэгжүүдийн мах, махан бүтээгдэхүүн хадгалдаг агуулах, хөлдөөгч нүхэн зоорь зэрэгт бэлтгэсэн мал, махны гарал үүслийн гэрчилгээнд өдөр бүр хяналт шалгалтыг явуулав.

Аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мал, мах өндөр үнээр авна гэсэн зарын дагуу 18 иргэнтэй холбогдон авсан мал, махыг бүртгэл судалгаанд авч Баянтүмэн, Булган суманд мал, мах авч байсан 3 ченжийг шинээр бүртгэн худалдан авсан малын гарал үүслийн гэрчилгээнд хяналт шалгалт явуулж, зурагжуулав.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хот болон өөр аймаг сумруу борлуулагдаж байгаа мал, махны гарал үүслийн гэрчилгээг шалган баталгаажуулан хонь 2858, адуу 2373, үхэр 669, ямаа 696, тэмээ 10 толгой малын гарал үүслийн гэрчилгээг баталгаажуулан зурагжуулан нэгдсэн сан бүрдүүлэн ажилласан байна.

Гарал гарал үүслийн бичиггүй мал, мах тээвэрлэсэн, гарал үүслийн бичгээ дутуу бүрдүүлсэн, биедээ авч яваагүй зэрэг зөрчил дутагдал гаргасан 25 иргэнд Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн заалт, орон нутгийн хэмжээнд дагаж мөрдөхөөр гаргасан аймаг, сумын Засаг даргын захирамжуудыг танилцуулж, дахин зөрчил гаргахгүй байх баталгаа бичүүлэн авах ажлыг зохион байгуулж ажиллав.

Алдагдсан болон алдуул мал бүрийг ASAP сангаар эрэн сурвалжлахаас гадна, цахим фэйсбүүк хаягт нээсэн “5-r bus”, “Dornod tsagdaa jijuur”, “Dornod & Khesgiin tsagdaa” хаалттай бүлгүүдээр 7 хоног бүрт эрэн сурвалжлах материал, тоотыг нийт сумдын хэсгийн төлөөлөгч, баг хариуцсан хэсгийн байцаагч нарт хүргүүлж, 7 хоног бүрийн Лхагва гарагт нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж, мэдээлэл солилцох, эрэн сурвалжлах ажиллагааг цахим хаягаар солилцож ажиллаж байна.

Цаг агаарын нөхцөл байдал, иргэд, малчдын малын хариулга, маллагаа, хариуцлагын байдлаас шалтгаалан олон тооны мал бэлчээр сэлгэн гүйх, олон хоногоор олдохгүй байгаа тохиолдолд гомдол, мэдээлэл шалгах хугацаанаас шалтгаалан хэрэг бүртгэлтийн хэрэг нээсний дараа алдагдсан мал олдож ирснийг бүртгэн хэргийг хаан шийдвэрлэж байна. Тухайлбал хэрэг бүртгэлтийн 192100005, 192100027, 192100035, 192100189 дугаартай хэргүүдэд эрэн сурвалжлагдаж байсан мал олдсон тул хэргийг хаах саналтай прокурорт хүргүүлэн ажиллалаа.

“Малчдын бүлэг” нэгдсэн арга хэмжээг 2 үе шаттайгаар зохион байгуулж, нийт 13 сумдад Хууль зүйн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/160, А/73 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Малчдын бүлэг ажиллуулах үлгэрчилсэн дүрэм"-ийг хэрэгжүүлэх, ”Малчдын бүлэг”-ийг сум бүрт байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулав.

“Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг аймгийн ГХУСАЗСЗ-ийн даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Малчдын бүлэг холбоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр сургалт зөвлөгөөн зохион байгуулах ажилд 2,0 сая төгрөг төсөвлөн ба иргэдийн сайн дурын үүсгэл санаачлагаар байгуулагдсан “Малчдын бүлэг”-үүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил, зөвлөгөөнийг сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлүүдтэй хамтран энэ оны 4 дүгээр улиралд зохион байгуулахаар ажиллаж байна.

Мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2019 оны 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл 60 хоногийн хугацаатай “Таван эрдэнэ” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж байна.

Энэ оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэг 111 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үетэй харьцуулахад 37 хэргээр буюу 50 хувиар өссөн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн болон Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн болон Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, орон нутгийн удирдлага, Цагдаагийн байгууллагын даргаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, Цагдаагийн ерөнхий газрын 2019 онд дэвшүүлсэн зорилтыг ажилдаа удирдлага болгон хүүхдээс гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, бууруулах, гэмт хэргийг таслан зогсоох, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагын хамтын оролцоонд тулгуурлан тодорхой төрлийн ажлуудыг хэрэгжүүлж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 2019 оны 3 дугаар улирлын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй нийт гомдол мэдээлэл 97 бүртгэгдсэнээс гэмт хэргийн шинжтэй 1, зөрчлийн шинжтэй 96 дуудлага мэдээлэл байгааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 6 хэргээр буурч, зөрчил 11 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 18 хүнд зөвлөгөө мэдээлэл өгч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан этгээдийн судалгааг сар бүр гарган Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүдэд хүргүүлэн хамтран ажиллах төлөвлөгөний дагуу хүчирхийлэл үйлдэгч нартай тогтмол уулзан, тэдний зан үйлийг засах ажлыг зохион байгуулж нийт 55 хүнд зан үйлд нөлөөлөх сургалтыг хамтран тогтмол зохион байгуулж ажилласан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөөг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйчтэй хамтран зөвлөгөө өгч холбон зуучлан ажиллахын зэрэгцээ хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх ажилд Өмгөөллийн холбооны өмгөөлөгч нарыг оролцуулан дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд хөгжил хамгаалал” үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, тогтоомжид заасны дагуу хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй эмзэг цэгүүдийг иргэд, олон нийтийн оролцоотой хяналтад авах зорилгоор “Хүүхэд хамгаалагч” төслийг аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Хүүхэд хамгаалагч” нарыг өдөр тутам мэргэжлийн удирдлагаар ханган хамтран ажиллалаа.

“Хичээлийн шинэ жил” арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын 8, 12 дугаар сургуулийн дунд ангийн хүүхдүүдэд “Гэмт хэрэг, зөрчлөөс өөрийгөө хэрхэн хамгаалах”, мөн сургуулийн нийгмийн ажилтнуудтай уулзаж “Сургууль аюулгүй бүс” эцэг, эхийн эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Энэ хугацаанд 2 багийн 6 сургууль, 4 цэцэрлэгийн орчинд ажиллан тухай бүрт нь сургуулийн “Эцэг, эх зохицуулагч”-ийг хуваарийн дагуу тогтмол ажиллуулах, зөвхөн автозамын орчимд ажиллах биш сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлийн нийт асуудалд анхаарч, хариуцлагатай ажиллах, ажилласан талаарх илтгэх хуудас танилцуулгыг дэлгэрэнгүй, тодорхой бичих, “Өсвөрийн цагдаа бүлгэм”-ийн сурагчид нь үйл ажиллагааныхаа чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудаас мэдээлэл авч, өөрсдийн болон үе

тэнгийнхнийхээ мэдлэг, мэдээллийг тогтмол нэмэгдүүлж байхад анхаарах, цэцэрлэгүүдийн хувьд бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрсдэлт нөхцөл байдлуудыг засч сайжруулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг чиглэл, зааварчилга өгөв.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 12 сургуулиас “Сургууль аюулгүй бүс” арга хэмжээний хүрээнд төсөл хэрэгжүүлэгч сургуулиудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн тусалцаа үзүүлэн сургуулийн эргүүлд гарч байгаа эцэг эхчүүдэд, Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад хуулийн талаар мэдээлэл хийж газар дээр нь очиж хяналт шалгалтыг явуулан үр дүнг тооцон ажиллав. Мөн хүүхдийг сургуулийн орчинд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар богино хэмжээний шторк үзүүлж, санал хүсэлтийг сонсож ерөнхий боловсролын 23 сургуульд хүүхэд хамгааллын бодлого “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал”-ын чиглэлээр олон талт нөлөөллийн ажлуудыг зохион байгуулан сургалт, сурталчилгааг хийж ажиллалаа. “Гар утасны зохистой хэрэглээ”, “Цахим орчинг зөв болгоё”, “Цахим ёс зүй” зэрэг сургалт, нөлөөллийн ажлыг нийт 236 сурагчдад хүргэн ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсээс гаргасан богино хэмжээний шторкуудыг Ерөнхий боловсролын сургуулиудад түгээж өдөр бүр 1 шторк үзүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс зохион байгуулж буй “Хичээлийн шинэ жил” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Дорнод” Их сургууль, Политехникийн коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн оюутнууд болон ерөнхий боловсролын сургуулийн нийт 400 гаруй сурагчдад цахим хэрэглээ, хар тамхины хор уршиг, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн талаар яриа таниулга хийж, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шторк үзүүлж ажиллалаа.

Цагдаагийн газрын дарга, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга нарын хамтарсан удирдамжийн дагуу Монгол улсын Засгийн газрын 2013 оны "Журам батлах тухай" 410 дугаар тогтоол, Хууль зүйн яамнаас батлан гаргасан Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг хангах, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 23 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2016 оны "Журмын хэрэгжилтийг хангуулах тухай" А/117 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 8 интернет цахим тоглоомын газруудад хяналт, шалгалтыг хамтран зохион байгуулж тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 1 газрын үйл ажиллагааг зогсоож хариуцлага тооцож ажиллалаа.

Мөн “Насанд хүрээгүй хүүхдийн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ын хүрээнд “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Зөрчлийн тухай” хуулиуд болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль эрх зүйн актын хэрэгжилтийг шалган илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 8 баар, 11 ресторан, 6 караоке, 8 дэн буудал, 12 зочид буудал, 6 массаж сауны газруудаар аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Онцгой байдлын газрын мэргэжилтнүүд нартай хамтран үзлэг шалгалтыг явуулан хяналт тавьж ажиллалаа.

Ардын хувьсгалын 98 жилийн ой, Дорнод аймаг байгуулагдсаны 88 жилийн ой, "Зүүн бүсийн хурд-2019", "Зүүн бүсийн чуулга харваа" зэрэг баяр наадам 2019 оны 07 дугаар сарын 27-ноос 28-ны өдрүүдэд зохион байгуулагдсантай холбогдуулан Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх мэргэжилтэн нар баяр наадмын өдрүүдэд Баянтүмэн сумын морь барианы орчим төөрсөн 4, төв цэнгэлдэх хүрээлэн орчим төөрсөн 15 хүүхдийг олж, эцэг, эхчүүдэд нь хүлээлгэн өгч ажиллалаа. Төөрсөн хүүхдүүдийг явуулын "Хүүхдийн түр хамгаалах байр"-нд хоол, ундаар үйлчилж, тайвшруулах, эцэг, эхчүүдэд зөвлөгөө өгөх, үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор эцэг, эхийн утасны дугаар бүхий бугуйвч тараах, наадмын зохион байгуулах комисстой хамтран узелээр сэрэмжлүүлэг, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зөвлөмж, голын эрэг дагуу алба хаагчдыг томилон амарч зугаалж буй иргэдэд хүүхдийн аюулгүй байдалд онцгой анхаарах, усанд осолдсон үед анхан шатны тусламж хэрхэн үзүүлэх талаар зөвлөмж, мэдээллийг тус тус хүргэж ажиллалаа.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамтыг илрүүлэх, мэдээлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэсэн шторк богино хэмжээний киног хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран иргэдэд хүргэх, мэдээллэх ажлуудыг тогтмол зохион байгуулж байна. Арга хэмжээний хүрээнд шторк, богино хэмжээний киног орон нутагт үйл ажиллагаа

явуулдаг 6 телевизээр 7 хоногт 5 удаагийн давтамжтайгаар 4 удаа явуулж олон дагагчтай фейсбүүк группүүдэд шейрлэж цахим орчинд түгээсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шүүгчийн шийтгэврээр саатуулагдсан 76 иргэдийн судалгааг Цагдаагийн байгууллагын бүртгэл хяналтын сангийн объект, субъектийн бүртгэлд авч, судалгааг шинэчилж, хамрагдсан иргэдэд нийгэмшүүлэх чиглэлээр аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Түвшин амьдрал” төрийн бус байгууллагатай хамтран “Ухаарахуй” сэдэвт сургалт, мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль, Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудаар сургалт мэдээллийг зохион байгуулж, санал хүсэлтийг нь хүлээн авч ажиллалаа. Мөн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газартай хамтран Нэг цэгийн үйлчилгээнд 4 хүүхдийг хүлээн авч, хамгааллын болон эрүүл мэндийн үйлчилгээ болон боловсролын үйлчилгээг тасралтгүй үзүүлэн ажилласан байна.

Цагдаагийн газар, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулах үеийн бэлтгэл ажлыг хангахад оролцож, орон нутгийн телевизэд 7 хоног бүр гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлж. хүүхэддээ тавих хараа хяналтыг сайжруулах санамж, сэрэмжлүүлгийг тогтмол өгч ажиллаж байна. Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс болон Цагдаагийн газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд түгээсэн шторк, богино хэмжээниий бичлэгүүдийг алба хаагчдаар болон Дорнод аймагт хандалт ихтэй фэйсбүүк группуудэд шейрлэж олон нийтэд хүргэх ажлыг өдөр бүр зохион байгуулж, илтгэх хуудсыг зүүн бүс хариуцсан мэргэжилтэн рүү явуулж ажиллалаа.

Сэтгэл зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код-938/ журамд заасны дагуу алба хаагчид сэтгэл зүйн тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээний чиглэлээр цагдаагийн алба хаагчийн сэтгэл зүйн байдлыг судлан оношлох, цагдаагийн байгууллагын алба хаагч, ажиллагсдад зориулсан сэтгэл зүйн сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, алба хаагч, ажиллагсдын хүсэлтээр сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл засал болон дэмжих бүлгийн ярилцлага хийх, мэргэжлийн тусламж, үйлчилгээний явцад гарсан асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, удирдлагад мэдээлэл өгөх, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалтад мэргэжлийн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах, мэргэжлийн мэдлэг, чадвараа хөгжүүлэх, шинийг санаачилж, хэрэгжүүлэх чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа.

Тасаг албадын дунд зохион байгуулж буй “Стрессгүй нэг өдөр” арга хэмжээний хүрээнд Цагдаагийн газрын сэтгэл зүйч цагдаагийн ахлах дэслэгч Y.Алтантуа нь 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдөр “Стресс ба мандала” сэдвээр Дотоодын цэргийн тусгай салааны алба хаагчдад сургалт зохион байгуулав.

Мөн тус салааны алба хаагчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдийг хамруулан 08 дугаар сарын 17-ны өдөр Цагдаагийн газраас “Бунхан толгой”-руу явган аялалыг зохион байгуулж ажиллалаа.

Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу тусгай салааны харуулын дарга, дэслэгч М.Энхбат 09 дүгээр сарын 09-ний өдөр “Бие хүний сэтгэл зүйн хувийн өвөрмөц онцлог” сэдвээр хичээл сургалт орж, алба хаагч нэг бүрээр сэтгэл зүйн чиглэлээр Холерик, Сангвиник, Флегматик, Меланхолик темпераментийн хэв шинжийг тогтоох санал асуулга авч, алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах зорилгоор сэтгэл зүйн хэв шинжийг тодорхойлж ажиллав.

Алба хаагчдын ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх, стрессийг тайлах зорилгоор 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн өглөөний яриа эхлэхээс өмнө хөнгөн намуухан ая, дуу сонсгон сэтгэл зүйн хэлц үгүүдийг дэлгэцээр гарган үзүүлж байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Òóñ àéì ãèéí õýì æýýí ä ãýì ò õýðýã, ýðõ ç¿éí çº ð÷èëòýé òýì öýõ ÷èãëýëýýð ãöäàì æ òàëáàé, î ëî í í èéòèéí ãàçàð áî ëî í ñî ãòóóãàòàð ¿éëäýãäñýí ãýì ò õýðãèéí ãàðàëòû ã òî äî ðõî é õóâèàð áóóðóóëàõ, çº ð÷èèéí èëð¿¿ëýëòèéã àõèóëàõ çî ðèëòû ã òàâüæýðã¿¿ë, ø àëãàëòû ã õóâààðü, õ¿í õ¿÷í èé òî î öî î ã ãàðãàí ãöäàì æòàëáàé, î ëî í í èéòèéí ãàçðû ãõýí äëòàí ä àâàõ, èðãýä áàéãóóëàãà àæàõóéí í ýãæýýñ èðæ áàéãàà äóóäëàãà ì ýäýýëýëä ø óóðõàé õàí äàõ, öàãäààãèéí ¿éë÷èëãýýãèðãýäýä õ¿ðãýõ, ýðã¿¿ëèéã î í î â÷òî é çî õèî í áàéãóóëàõ ÷èãëýëýýð àâòî õº äº ëãº º í òýðã¿¿ëèéã àéì ãèéí òº âèéí 10 áàãèéã 4 á¿ñ÷ëýëä õóâààæçî õèî í áàéãóóëàí àæèëëàæáàéí à.

Àéì ãèéí õýì æýýí ä бүртгэгдсэн ãýì ò õýðýã çºð÷ëèéí гаралт, öàã õóãàöàà, ¿éëäëèéí àðãà, ø àëòãààí íºõöºëä êðèì èí î ëî ãè ñóäàëãàà õèéæ ýì çýã öýã õýñýã ãýì ò õýðýã çºð÷ëè ãàð÷ áî ëçî ø ã¿é ãàçðûí ñóäàëãàààã ãàðãàí , õýâ æóðì ûí ýðã¿¿èéã çî õèî í áàéãóóëàõäàà àëáà õààã÷ í àðò àí õààðóóëàí , õÿí àëò òàâèõ ÷èãëýëýýð ¿¿ðýã çààâàð÷èëãààð õàí ãàí àæëëóóëæáàéí à.

Çî ÷èä, òº ëºº ëº ã÷äèéí áî ëîí áàÿðíàäì ûí õàì ãàäëàëòûí òàëààð: Халхын голын дайны ялалтын 80 жилийн ойг 2019 оны 08 дугаар сарын 23-наас 09 дүгээр сарын 06-ны хооронд хөтөлбөр төлөвлөгөөний дагуу тэмдэглэн өнгөрүүллээ. Энэхүү ажлын хүрээнд Халхын голын дайнд оролцсон Монгол дайчдын хөшөөн, Зөвлөлтийн нисэгчдийн хөшөөнд хүндэтгэл үзүүлэх, “Халхын гол 80” гэрэл зургийн үзэсгэлэн, Монгол улс, Оросын холбооны улсын хамтарсан “Сэлэнгэ-2019” тактикийн хээрийн сургуулилт, “Дайнд мордсон охид” баримтат киноны нээлт, Оросын холбооны улсын цэргийн ансамблийн тоглолт зэрэг арга хэмжээ, үйл ажиллагаанууд зохион байгуулагдлаа.

Халхын голын дайны ялалтын 80 жилийн ойн хүрээнд зохион байгуулах дайны үеийн автомашиныг сэргээн засварлах уралдааны шалгаруулалт, Хэрлэн сум 3 дугаар багт байрлах “Монгол дайчдын хөшөө”-ний өмнө “Мөнхийн гал” асаах арга хэмжээ 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 11:00 цагт зохион байгуулагдаж, 800 орчим иргэд үзэж сонирхон, хамгаалалтад цагдаагийн газраас 12 алба хаагч 2 автомашинтай, 08 дугаар сарын 25-ны аймгийн Хөгжимт драмын театрт зохион байгуулагдсан Оросын холбооны улсын цэргийн ансамблийн урлагийн тоглолтын хамгаалалтад цагдаагийн газраас 3 алба хаагч 1 автомашинтай үүрэг гүйцэтгэж шугам зам болон иргэдийн хөдөлгөөнд хэв журам сахиулан ажиллалаа.

Монгол улс, Оросын Холбооны Улсын Зэвсэгт хүчний хамтарсан “Сэлэнгэ-2019” байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулилт Хэрлэн сум 5 дугаар баг Өгөөмөр гэх газар Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн сургуулилтын талбайд 08 дугаар сарын 27-ны өдрийн 10:00 цагаас 13:00 цагийн хооронд зохион байгуулагдаж, тус сургуулилтыг үзэж сонирхохоор 20000 орчим иргэд оролцон сонирхож, цагдаагийн газраас 8 автомашин, 3 мотоцикль, 122 алба хаагчийн хүн хүчээр хамгаалалтыг зохион байгуулан ажиллав.

Халхын голын дайны ялалтын 80 жилийн ойн баярт зориулан Хэрлэн сумын 1 дүгээр багт байрлах “Зөвлөлтийн нисэгчдийн хөшөө”-нд хүндэтгэл үзүүлэн цэцэг өргөх арга хэмжээ 08 дугаар сарын 28-ны өдрийн 09-09:40 цагийн хооронд зохион байгуулагдаж, 10:00-11:00 цагийн хооронд Хэрлэн сумын 3 дугаар багт байрлах “Монгол дайчдын хөшөө”-нд хүндэтгэл үзүүлэн цэцэг өргөх, Оросын холбооны улс, Монгол улсын зэвсэгт хүчний хамтарсан ёслолын жагсаал болон урлагийн бусад арга хэмжээнүүд хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдаж, уг арга хэмжээг 5000 орчим иргэн үзэж, хамгаалалтад цагдаагийн газраас 92 алба хаагч, 8 автомашин, 3 мотоцикл, тусгай хэрэгсэл техник хүчтэйгээр хамгаалалтыг амжилттай зохион байгуулан ажиллалаа. Мөн энэ өдөр аймгийн Хөгжимт драмын театрт зохион байгуулагдсан Халхын голын 80 жилийн ойн баярын хурал, хүндэтгэлийн концерт, “Дайнд мордсон охид” баримтат киноны нээлтийн арга хэмжээний хамгаалалтад тус газраас 4 алба хаагч үүрэг гүйцэтгэж ажилласан байна.

Хэрлэн сумын 7 дугаар багт байрлах “Тусгаар тогтнолын тайлбай”-д үдшийн цэнгүүн, шоуны арга хэмжээ 08 дугаар сарын 28-ны өдрийн 21:00 цагаас 00:00 цагийн хооронд зохион байгуулагдаж, 3000 орчим иргэд оролцсоноос гадна гадаадын зочид төлөөлөгчид 600 орчим хамрагдлаа. Цагдаагийн газраас 62 алба хаагч, 6 автомашин, 3 мотоциклийн хүн хүчтэйгээр хамгаалалтыг зохион байгуулан ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажиллалаа.

“Халхын голын дайны ялалтын 80 жилийн ой”-н арга хэмжээний хамгаалалтад оролцох алба хаагчдын хуваарийг гарган Цагдаагийн газрын даргаар батлуулж, 09 дүгээр сарын 01-ний өдрийн 14.00 цагт цуглуулж, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Замын цагдаагийн тасгийн дарга нараас үүрэг, чиглэл өгч, бичгээр баталгаа гаргуулан авч, 09 дүгээр сарын 02-ны өдрийн 06.00 цагт замын цагдаагийн тасгийн даргаар ахлуулан Фургон маркийн автомашинтай 20 алба хаагч Халхгол сумын чиглэлд гарч 16.00 цагт очсон.

Энэ өдөр Халхгол сумын төвд 18.00-23.30 цагийн хооронд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төв замын уулзвар, Хамар даваа, шинэ сум, онон голын гүүр зэрэг замын хөдөлгөөний нягтрал ихтэй хэсгүүдэд 4 алба хаагч, хэв журам сахиулах чиглэлээр явганаар 5 чиглэлд 10 алба хаагч, авто хөдөлгөөнт эргүүлээр 1 чиглэлд 2 алба хаагч, шөнийн эргүүлд 1 автомашинтай 2 алба хаагч гарч тус тус үүрэг гүйцэтгэсэн байна.

“Халхын голын дайны ялалтын 80 жилийн ой”-н арга хэмжээ батлагдсан хөтөлбөрийн дагуу 2019 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 07.00 цагаас хөшөөнд цэцэг өргөх үйл

ажиллагаагаар эхэлж, Замын цагдаагийн тасгийн дарга Ланд круйзер 76 маркийн автомашинтай цувааны хөтөч хамгаалалтыг зохион байгуулан ажилласан.

Ялалтын хөшөөнд цэцэг өргөх үйл ажиллагаа 11.00 цагт эхэлж, хамгаалалтыг Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч хариуцсан нийт 7 алба хаагчийн хүчээр зохион байгуулав. Тус үйл ажиллагааны дараа "Шинэ сум" төслийн нээлт, баярын хурал, хүндэтгэлийн концерт, орой 21.30-01.00 цаг хүртэл "Ялалтын дуутай үдэш цэнгүүн"-ний арга хэмжээ тус тус зохион байгуулагдаж, хамгаалалтад нийт 35 алба хаагч оролцлоо.

Мөн 09 дүгээр сарын 04-ний өдөр батлагдсан хөтөлбөрийн дагуу 06.00 цагт их насны морины уралдаанаар баярын үйл ажиллагаа эхэлж, соёолон, хязаалан насны морьдын уралдаан өдрийн 16.00 цаг хүртэл зохион байгуулагдаж хамгаалалтад 5 автомашинтай 24 алба хаагч, наадмын талбайн хамгаалалтад 6 алба хаагч, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 5, нийт 35 алба хаагч ажилласан. Үзүүр түрүүний бөхийн барилдаан, морь цоллох үйл ажиллагааны хамгаалалтыг томилогдсон бүрэлдэхүүний хүчээр мөн зохион байгууллаа.

Халхголын сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ц.Дайчинхүү, хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч М.Энхболд нар "Халхын голын дайны ялалтын 80 жилийн ой"-н хаалтын шоу зохион байгуулагдах хуучин Музейн гадна хэсэгт 4 чиглэлд 8 алба хаагчийг, дотор хэсэгт 4 чиглэлд 8 алба хаагчийг тус тус томилон ажиллуулав.

Хамгаалалт тус бүрийг тасгийн дарга, ахлах байцаагч нараас хариуцсан зохион байгуулсан бөгөөд хамгаалалтыг нийт давхардсан тоогоор 9 хэсэгт зохион байгуулж, төлөвлөгөө, зураглалын дагуу 5 хөшөө, дурсгал, олон нийтийн талбай, 4 үзвэр үйлчилгээний газар, 9 авто зогсоол, 5 уулзвар, гарцыг хяналтдаа авч, цагдаагийн газраас 6 автомашин, 17 офицер, 17 ахлагч, Шүүхийн шинжилгээний албанаас 1 офицер, нийт 35 цагдаагийн алба хаагч ажиллаж, хамгаалалтыг хэвийн гүйцэтгэсэн.

Бусад хамгаалалтын талаар: Баянтүмэн сумын 80 жилийн ойн баяр наадам 2019 оны 07 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд, Аймгийн баяр наадам болон Зүүнбүсийн "Их хурд-2019" наадам 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд, "Дорнод гурил" компаний 80 жилийн ойн арга хэмжээ 2019 оны 08 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд Баянтүмэн суманд, "Чойбалсан хот"-ын алдар гавьяаны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ 2019 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр Хэрлэн сумын 7 дугаар баг "Тусгаар тогтнолын талбай"-д, Улаанбаатар төмөр замын "Баянтүмэн тасгийн 80 жилийн ойн" арга хэмжээ Хэрлэн сумын 8 дугаар баг, Баянтүмэн суманд 09 дүгээр сарын 13-14-ны өдрүүдэд тус тус зохион явагдсаныг батлагдсан төлөвлөгөө удирдамжийн дагуу хамгаалалтыг ямар нэгэн хэрэг, зөрчилгүй зохион байгуулж ажилласан байна.

Õî ðèî öýýðèéí äýãëýì èéí òàëàà: Баян-Дун сумын төвд малын гоц халдварт боом өвчин гарсантай холбогдуулан 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 26-ны өдөр хүртэл хяналтын 2 постод цагдаагийн 4 алба хаагч үүрэг гүйцэтгэж ажиллав.

ГУРАВ. САХИЛГА ХАРИУЦЛАГА, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, АВИЛГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ТАЛААР

А. Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүн.

Öàãäàäàãèéí ãàçàð íü 2019 îíä Öàãäàäàãèéí åðºíõèé ãàçðàäàñ äýâø¿¿ëñýí çîðèëòûã õýðýãæ¿¿ëýõ, Öàãäàäàãèéí áàéãóóëäàãûí ¿éë÷èëãýýí èé ñòàí äàðò, öàãäàäàãèéí àëáà õàäã÷èéí ¸ñ ç¿éí õýì õýì æýýã õýâø¿¿ëýõ òàëäàð îëîí òºðëèéí àðãà õýì æýýí ¿¿äèéã çîõèî íáàéãóóëæ çºð÷ëè äóòàãäàë ãàðãàñàí àëáà õàäã÷ íýãá¿ðòýé õàðèöëàãà òî îõî íáæèëèàà.

Цагдаагийн байгууллага, ажилтан алба хаагчдаас Монгол улсын хууль, тогтоомж, òºðèéí àëáàí û çàð÷èì ¸ñç¿éí õýì õýì æýýãñàõèí áèåë¿¿ëæ, àæûí áàéðàí ä àæèë õýðýã÷ óóð àì üñãàëûã á¿ðä¿¿ëýõ, ¿éë÷èëãýýí èé ÷àí àðûã ñàéæóóëàõ çîðèëãî ð Öàãäàäàãèéí åðºíõèé газрын даргын 2009 оны 403 дугаар тушаалаар батлан гаргасан "Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт", Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 23-íû өдрийн А/129 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм", 2 дугаар хавсралтаар батлагдсан "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-

ийг хэрэгжүүлэх, агуулга, ач холбогдлыг тайлбарлан таниулах, судлуулах, үйл ажиллагаанд í ü õýâø ¿¿ëýõ, èðãýä î ëî í í èéòýä ñóðòàë÷ëàõ àæëû ãòî ãòì î ë çî õèî í áàéãóóëæáàéí à.

Албадын дарга нарын манлайлал, бүтээлч ажиллагаа, алба хаагчдын сахилга ёс зүй, цагдаач шуурхай ажиллагааг хангаагүй, шат дараалсан шаардлага, хяналт сул байгаа байдлыг юуны түрүүнд сайжруулах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Энэ хугацаанд “Сахилга ёс зүйн алба”-ыг 2 удаа хуралдуулж, сахилга ёс зүйн зөрчил гаргасан 99 алба хаагч /давхардсан тоогоор/-ийн талаар хэлэлцэж, 17 алба хаагчид дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг сануулж, 66 алба хаагчид ажлын үр дүнгээр цалинг хасах, 16 алба хаагчид нөлөөллийн арга хэмжээ авч шийдвэрлэв.

Хурлаар Цагдаагийн газрын удирдлагаас өгсөн үүргийн биелэлтийг хангалтгүй гүйцэтгэсэн, албаны бэлэн байдал хангаагүй, ажлын цаг ашиглалт хангалтгүй, олон нийтийн арга хэмжээнд идэвх санаачилга гаргаагүй алба хаагчдыг тус тус авч хэлэлцэн шийдвэрлэв. Зөрчил дутагдал гаргаж “Сахилга ёс зүйн алба”-ны хурлаар хэлэлцэгдсэн алба хаагч бүрээс дахин давтан зөрчил гаргахгүй байх “Баталгаа”-г 78 алба хаагчаас гаргуулан авч зөвлөгөө өгөв.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангах, ажлын хариуцлага, сахилга ёс зүйн байдалд дүгнэлт хийх, зөрчил дутагдлыг засах, алба хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн газрын 2019 оны 3 дугаар улирлын сахилга хариуцлагын зөвлөгөөнийг 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж, батлагдсан удирдамжийн дагуу жагсаалын үзлэгээр эхэлж, алба хаагчдын бэлэн байдлыг шалган ажиллалаа.

Сахилга хариуцлагын зөвлөгөөний үеэр Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Отгонбаатар “Цагдаагийн газрын 2019 оны 3 дугаар улирлын алба хаагчдын сахилга, ёс зүй байдал, анхаарах асуудал”-аар мэдээлэл хийж, сахилгын зөрчил гаргасан 4 алба хаагчид “АЛБАН ШААРДЛАГА”, хамт олноос нь сахилгын зөрчил гаргасан 3 тасгийн дарга нарт “АЛБАН МЭДЭГДЭЛ”, сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргалгүй ажилласан 5 тасгийн дарга, хамт олноо манлайлан ажилласан 3 алба хаагчид “ТАЛАРХАЛ” гардуулав.

Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзоригоос нийт бие бүрэлдэхүүнд мэргэжлийн ур чадвар, ажлын хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр 9, сахилга бат, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр 6 төрлийн үүргийг өгч, “ЭЕРЭГ ХАНДЛАГЫГ ТӨЛӨВШҮҮЛЖ, ЭВСЭГ ХАМТ ОЛНЫГ БҮРДҮҮЛЬЕ” уриалгыг гарган сахилга хариуцлага, ёс зүй, ажлын үр дүнгээ дээшлүүлж ажиллахаа илэрхийлэн хамт олон санал нэгтэй гар өргөн баталж, уриалгыг дэмжлээ.

Зөвлөгөөний төгсгөлд алба хаагчдын манлайлал, тэдний сайн талыг сурталчлах зорилгоор 11 алба хаагчийн “Сайн туршлага”-ыг алба хаагчдад танилцуулж, бие бүрэлдэхүүн ая дуугаар түрлэг өргөн зөвлөгөөнийг өндөрлөлөө.

Б. Алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр дотооддоо зохион байгуулсан сургалт.

Дорнод аймаг дахь Цагдаагийн газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/28 тоот тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө”, Байгууллагын хэмжээнд бие бүрэлдэхүүнд зохион явуулах сургалтын 2019 оны нэгдсэн төлөвлөгөө, хуваарийг цагдаагийн газрын даргаар батлуулж, алба хаагчдын үүрэг гүйцэтгэх ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйг төлөвшүүлэх, хууль хэрэглэх чадварыг дээшлүүлэх чиглэлээр нэгдсэн болон мэргэжлийн холбогдолтой сургалтуудыг 7 хоног бүрийн “Баасан”, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлж, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээнийг зохион байгуулж, албаны спортыг хөгжүүлж, албаны бэлтгэлийг хангах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхтэй холбоотой сургалтыг “Пүрэв” гарагуудад тогтмол явуулж ирлээ.

Албаны сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор 2019 онд алба хаагчдаас санал асуулгыг авч нэгтгэн, удирдлагад танилцуулан санал асуулгын дүнд үндэслэн 2019 онд зохион байгуулагдах 46 заалт бүхий сургалтын нэгдсэн төлөвлөгөөг гарган батлуулснаас 3 дугаар улиралд 26 удаагийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион явуулж нийт давхардсан тоогоор 2859 алба хаагч хамрагдаж, сургалтын ирц 70 хувьтай явагдлаа.

Бие бүрэлдэхүүнд мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалт 12, алба хаагчийг хөгжүүлэх сургалт 7, бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалтыг 7 удаа зохион явуулж, танхимын сургалтыг 26 удаа зохион байгуулж, хичээл сургалтад 10 видео хичээл ашиглан явуулав.

Цагдаагийн газрын хэмжээнд 2019 оны 3 дугаар улиралд шинээр томилогдсон 1 алба хаагчийг "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх" /код 944/-д заасны дагуу томилогдсон албан тушаалд богино хугацаанд дасан зохицох хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр дадлагажуулагч багшийг тушаалаар томилон, алба хаах болон багш шавийн гурван талт гэрээг байгуулан ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/28 тоот тушаалаар батлагдсан "Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу 2019 оны 3 дугаар улиралд ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх 8 удаагийн сургалтад 8 алба хаагч, гадаад улсад хилийн хамтын ажиллагааны чиглэлээр 1 алба хаагч, бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад 1 алба хаагч, нийт 10 удаагийн сургалтад 10 алба хаагчийг хамруулж, алба хаагчдад аюулгүй байдлыг хангах, сахилга ёс зүйтэй сургалтад хамрагдах талаар тусгайлан үүрэг чиглэл өгч баталгаа бичүүлэн авч ажиллаж байна.

ЦЕГ-ын даргын 2019 оны Б/656 дугаар тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилд "Цагдаагийн ажил эрх зүй" мэргэжлийн эчнээ сургалтад нэр бүхий 6 алба хаагчийг хамруулан суралцаж байгаа болно.

Мэдвэл зохих хууль, тогтоомжийн сургалтын хүрээнд Цагдаагийн газрын эхний хагас жилийн "Сахилга хариуцлагын зөвлөгөөн, нэгдсэн цугларалт"-ыг 2019 оны 06 дугаар сарын 29-ний өдөр сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг хамруулан зохион байгуулж, нийт 116 алба хаагч хамрагдлаа. Сахилга хариуцлагын зөвлөгөөний үеэр нийт бие бүрэлдэхүүнд "Хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад гарч буй зөрчил, анхаарах асуудал" сэдвээр Прокурорын газрын туслах прокурор Б.Батжаргал нар сургалт явуулж, цаашид анхаарах асуудлаар харилцан ярилцлага зохион байгуулав.

Цагдаагийн байгууллагын дотоод албаны шинэчилсэн дүрмээр 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр алба хаагчдад сургалт явуулж, мөн Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн сургалтын төвөөс зохион явагдсан цахим сургалтад галт зэвсэг биедээ авч явах эрх бүхий 113 алба хаагчдыг хамруулав.

Шинээр батлагдсан хууль, тогтоомж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар бие бүрэлдэхүүнд сургалтын материал бэлтгэн байгууллагын "Dornod surgalt" хаалттай группт байршуулан алба хаагчдаар судлуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Алба хаагчийг хөгжүүлэх сургалтын хүрээнд тасгийн дарга, ахлахуудаас "Стресс ба түүний шалтгаан, оношилгоо, тусламж" сэдэвт сэтгэлзүйн цуврал хичээлүүдээр сургалтын материал бэлтгэн 3 дугаар улиралд "Стрессийн ерөнхий ойлголт", "Сэтгэцийн эрүүл мэндийн тухай ойлголт", "Стрессээс урьдчилан сэргийлэх энгийн аргууд", "Сэтгэл түгшилт ба түгээмэл сэтгэл түгших эмгэг", "Сандрах эмгэг", "Биеийн хэлбэрийн эмгэгүүд", "улигт бодол албадмал үйлдлийн эмгэг", "Архаг ядаргаа", "Стресст өгөх цочмог хариу үйлдэл", "Хүнд стресст өгөх хариу урвал ба дасан зохицох хямрал", "Гэмтлийн дараах стрессийн хариу үйлдэл" зэрэг сэдвүүдээр алба хаагчдад нийт 11 удаа сургалтыг явуулав.

Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд "Харилцааны ёс зүй" сэдвээр аймгийн Боловсрол соёлын газрын мэргэжилтэн Г.Мөнгөнтуул, "Мэдээллийн аюулгүй байдал" сэдвээр Тагнуулын газрын дарга д/х Н.Бямбаа, "Ашиг сонирхолын зөрчил" сэдвээр аймгийн Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөцийн ахлах мэргэжилтэн Э.Нандин-Эрдэнэ нар 2019 оны 06 дугаар сарын 29-ний өдөр сургалт зохион байгуулав.

Дадлагажуулах сургалтын хүрээнд алба хаагчдыг мэдлэгийг дээшлүүлэх, хууль эрх зүйн туслалцаа авах, код журмуудыг судлах, "Police code" апплейкшнийг ашиглах, хэрэглэх арга барилд сургах, дадлагажуулах зорилгоор холбооны инженер, цагдаагийн ахмад В.Болормаа 2019 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр бие бүрэлдэхүүнд сургалт явуулав.

Цагдаагийн албаны тухай хуулийн 22, 29 дүгээр зүйл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "код-209, 214, 222, 223, 232, 234, 629", "Галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх журам"-даар бэлтгэн ирүүлсэн 10 төрлийн видео хичээлийг алба хаагчдад судлуулах, дадлагажуулах сургалтыг явуулав.

Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Соён гэгээрүүлэх ажил” /код 940/ журам”, “Биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах” ЦБҮАЖ /код 941/, мөн даргын А/135 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл цагдаа” хөтөлбөр, цагдаагийн газрын 2019 онд бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулагдах “Соён гэгээрүүлэх ажил”-ын төлөвлөгөөний хүрээнд Цагдаагийн газрын даргаар 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөр батлагдсан “Тэмдэглэлт баяр, ёслолын арга хэмжээ”, “Биеийн тамир спортын уралдаан тэмцээн”-ний хуваарийн дагуу арга хэмжээнүүдийг зохион явуулж дүгнэлээ.

Цагдаагийн газраас алба хаагчдын дунд “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын өдөр”-ийг 2019 оны 07 дугаар сарын 19-ний өдөр “Ухаа арал” амралтын газарт тэмдэглэн өнгөрүүлж, арга хэмжээний хүрээнд Үндэсний бөхийн барилдааныг зохион явуулж 35 бөх барилдсанаас Дотоодын цэргийн тусгай салааны харуулчин, ахлах ахлагч Б.Даваадорж түрүүлж, Захиргаа удирдлагын тасгийн нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч Б.Ганзориг үзүүрлэж, Захиргаа удирдлагын тасгийн цагдаа жолооч, цагдаагийн дэд ахлагч Ж.Цолмон, Дотоодын цэргийн тусгай салааны харуулчин, ахлагч Ю.Шинэцогт нар шөвгөрлөө.

Шагайн харваан тэмцээнд тасаг бүрээс 2 алба хаагч нийт 16 алба хаагч оролцож цэц мэргэнээ сорьсноос Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч цагдаагийн дэслэгч Б.Даваахүү түрүүлж, Дэд байранд Замын цагдаагийн тасгийн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Б.Үнэнбат, гуравдугаар байранд Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч цагдаагийн хошууч М.Энхболд нар тус тус байр эзэллээ.

Үндэсний сурын харваанд тасаг бүрээс 2 алба хаагч нийт 16 алба хаагч оролцож цэц мэргэнээ сорьж өрсөлдсөнөөс Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Очирпүрэв түрүүлж, Дэд байранд Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Г.Баттөмөр, гуравдугаар байранд Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч цагдаагийн дэслэгч Х.Нямдаваа нар тус тус байранд шалгарлаа.

Баярын арга хэмжээнд алба хаагчдын гэр бүлийг хамруулсан холимог багийн “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг зохион байгуулснаас Дотоодын цэргийн тусгай салааны баг тамирчид Тэргүүн байр, Шуурхай удирдлагын тасгийн баг тамирчид Дэд байр, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн баг тамирчид гуравдугаар байрыг тус тус эзэлж Өргөмжлөл, медаль, үнэ бүхий зүйлсээр шагнагдсан байна.

- Цагдаа, Дотоодын цэргийн анги байгууллагуудын хэмжээнд 2019 онд зохион явагдсан 2 уралдаан, тэмцээнд 15 алба хаагчид оролцлоо. Үүнд:

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газрын нэрэмжит аварга шалгаруулах “ДАРТС”-ийн тэмцээнд тус цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч А.Дэлгэрбат, харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Ц.Эрдэнэсүрэн нарын алба хаагчид оролцож эрэгтэй ганцаарчилсан төрөлд 5 дугаар байр, холимог хосын төрөлд шигшээ 16-д шалгарсан амжилт үзүүлэв.

Тээврийн цагдаагийн албаны нэрэмжит аварга шалгаруулах “Хөл бөмбөг”-ийн тэмцээнд Эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Энхтөр ахлагчтай 13 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчдыг хамруулж, шөвгийн 16-д шалгарсан амжилтуудыг үзүүлэв.

- Аймгийн хэмжээнд зохион явагдсан уралдаан тэмцээнүүдэд алба хаагчдыг оролцуулж дараах амжилтуудыг гаргав. Үүнд:

